



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөдлөх хөрөнгө нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 218 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ТОГТООХ нь;

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянхонгор сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлалтай, 1975 онд ашиглалтад орсон, 80 м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах доод үнийг 29,724,800.00 /Хорин есөн сая долоон зуун хорин дөрвөн мянга найман зуун/ төгрөгөөр тогтоосугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс /Ц.Баяр-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахад оролцогчоос тавих дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 10 хувь буюу 2,972,480.00 /Хоёр сая есөн зуун далан хоёр мянга дөрвөн зуун наян/ төгрөгөөр тогтоосугай.

4. Нээлттэй дуудлагын худалдааны үнэ өсгөн нэмэгдүүлэх доод хязгаарыг 1,000,000.00 /Нэг сая/ төгрөгөөр тогтоосугай.

5. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний зардал 500,000.00 /Таван зуун мянган/ төгрөгийг дуудлагын худалдааны орлогоос санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Ж.Мөнхтүвшин/-д зөвшөөрсүгэй.

6. Шинэ өмчлөгчид шилжих хүртэлх хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллахыг Итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Эрэвгийлхам, Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал тус тус үүрэг болгосугай.

7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль эрх зүйн хэлтэс /Б.Эрдэнэбаяр/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР